



**ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 09 сарын 23 өдөр

Дугаар 8/56

Чингис хот

Буцалтгүй тусламж олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5, 16.5.5, Аймгийн Засаг даргын Тамгын газрын “Дотоод журам”-ын 7 дугаар зүйлийн 7.13 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын дотоод журамд заасны дагуу шинээр хүүхэдтэй болсон, шинэ байранд орсон нэр бүхий албан хаагчдад 450,000 (дөрвөн зуун тавин мянга) төгрөгийн буцалтгүй тусламж олгосугай.

2. Албан хаагчдын нэрсийг хавсралтаар баталсугай.

3. Буцалтгүй тусламжид шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын тэтгэмж, урамшууллын зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүний нөөцийн удирдлага, агентлаг хариуцсан мэргэжилтэн (С.Оюун-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын
2021 оны 9 дүгээр сарын 16 өдрийн
Б/З.Б. дугаар тушаалын хавсралт

№	Албан хаагчдын нэрс	Албан тушаал	Утга	Мөнгөн дүн
1.	Ж.Саруултөгс	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэрэгжилтэн	2 ихэр хүүхэдтэй болсон	100,000
2.	Л.Наранбат	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэрэгжилтэн	Хүүхэдтэй болсон	50,000
3.	Ц.Бат-Эрдэнэ	Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн	Хүүхэдтэй болсон	50,000
4.	Э.Ариунтунгалаг	Нягтлан	Хүүхэдтэй болсон	50,000
			Шинэ байранд орсон	150,000
5.	Т.Энхтуяа	Бичээч	Хүүхэдтэй болсон	50,000
	Нийт			450,000